



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 24 өдөр

Дугаар А/610

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн даргын 01/3652 тоот албан бичгийн дагуу Дэлхийн банкны санхүүжилттэй “Экспортыг дэмжих” төслийн хүрээнд Хүнс хөдөө аж ахуйн яамнаас зарласан “Экспортын чиг баримжаатай, импортыг орлох бүтээгдэхүүний агуулахын тоног төхөөрөмж” нийлүүлэх” гэрээ хийсэн “Тамирын бугат” ХХК –ны нийлүүлж буй тоног төхөөрөмжийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Я.Эрхэмбаяр (Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга)

Ажлын хэсгийн гишүүд: Д.Чинзориг (аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн )

Д.Эрдэнэхуяг (“Тамирын бугат” ХХК-ийн менежер)

А.Энхжаргал (Аймгийн Орон нутгийн өмчийн газрын нутгийн захиргааны байгууллагын өмчийн бүртгэл, хяналт хариуцсан мэргэжилтэн)

Ж.Балдандорж (Хөвсгөл шимт хөрс хоршооны захирал)

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга: Б.Цолмонбаяр (Аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын үйлдвэр худалдаа үйлчилгээний албаны дарга)

2. Тоног төхөөрөмжийг хүлээн авах ажлыг зохион байгуулж, холбогдох бичиг баримтыг бүрдүүлж, Хүнс хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Я.Эрхэмбаяр)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Захирамж-2023

6710011413